

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ БОЛОХ ЗАМЫН ПАСПОРТ, ГҮҮРИЙН КАРТ ХӨТЛӨХ ЗААВАР

НЭГ. Нийтлэг үндэслэл

Авто замын засвар, арчлалтын ажлыг оновчтойгоор төлөвлөн, зохион байгуулахад зориулан хэрэгцээт мэдээ, материалыг цуглуулах, судлах, төлөвлөх, мэдээлэх зорилгоор авто зам, замын байгууламжийн мэдээллийн санд авто замын техникийн бүртгэл паспорт, гүүрийн картыг хөтөлнө.

Авто замын техникийн паспорт нь авто зам, замын байгууламжууд, түүний тэмдэгжүүлэлт болон туслах тоноглолуудын техникийн тодорхойлолт, бүтэц, хийцийн онцлогууд, техник ашиглалтын байдлын тухай материалыг нэгтгэсэн мэдээлэлтэй байх ёстой.

Паспортыг замын чиглэл бүрт доорх үндсэн элементүүдээр 1 км тутамд хөтөлнө.

- Шороон далан – түүний үндсэн хэмжээнүүд, далангийн хөрс, уулын ба өөрийн шуудуу, далангийн бэхэлгээний төрлүүдийг тэмдэглэх бөгөөд уг тэмдэглэгээг үгээр бичнэ.
- Хучилт – Түүний төрөл, хийц, үндсэн хэмжээнүүд, үеүдийн материал, хөвөөний байдал /материалын зузаан, төрлийг бичнэ/
- Хиймэл байгууламж – гүүр, хоолой болон бусад төрлийн ус нэвтрүүлэх, янз бүрийн зориулалттай хиймэл байгууламж, тэдгээрийн хийц маяг, үндсэн хэмжээнүүд, бүтээцийн материалууд, ашиглалтад орсон он.
- Замын тэмдэгжүүлэлт – Замын баруун зүүн талд тэмдэгийн дугаар.
- Авто зам, гүүрийн ашиглалтын байдал.
- Авто зам, замын байгууламжийн газар зүйн байршил.
- Тухайн чиглэлийн авто замд хийгдсэн засвар арчлалтын тухай тэмдэглэл зэргээс бүрдэнэ.

Паспорт хөтлөх, баяжуулалт хийх ажлыг хоёр үе шаттайгаар явуулна.

1. Хээрийн ажил. Зам, гүүр болон бусад байгууламжуудад гадаад байдлаар нь ажиглалт, хэмжилт хийх, багаж хэрэгслийн тусламжтайгаар ашиглалтын техникийн нөхцөлүүдийг нарийвчлан хэмжиж, тэмдэглэл хийх.

Хээрийн судалгаа, үзлэг нь тухайн онд авто зам, хиймэл байгууламжуудад гарсан эвдрэл гэмтэл, өөрчлөлтүүдийг илрүүлэх, тодорхойлох зорилготой байна.

2. Боловсруулах ажил. Хээрийн үзлэг, судалгааны материал хэмжилтүүдийг боловсруулан паспортжуулалтад нэмэлт бичилт, баяжуулалт, тэмдэглэл хийх ажлууд орно.

Паспорт нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Авто замын паспорт /замын ерөнхий схем буюу шугаман график/ хүснэгтэн мэдээлэл, замын км-ын ерөнхий байдлын фото зураг.
2. Гүүрийн бүртгэл мэдээллийн карт, гүүрийн ерөнхий байдлын фото зураг.
3. Хоолойн бүртгэл мэдээллийн карт, хоолойн ерөнхий байдлын зураг.
4. Газар зүйн солбицолын жагсаалт
5. Тухайн зам, замын байгууламжийн ажлын зураг, төсөв, бусад тайлан мэдээлэл.

Энэ нь бүртгэл мэдээллийн сангийн ажлын зохион байгуулалтыг түргэн шуурхай болгох, техникийн албан ёсны баримтаар харилцан хяналт шалгалт тавих, замын ашиглалт, засварын удирдлагыг нарийвчлан, зохион байгуулалтыг сайжруулахад ашиглагдана.

ХОЁР. Авто замын паспорт хөтлөлт

Паспортын үндсэн хүснэгтийг дараах байдлаар хөтөлнө.

1-р мөр: Замын эхлэлээс эхлэн дэс дараалан тодорхой замын дагуу хэсэгт хамаарагдах газар нутгийн нэрийг бичнэ.

Жишээлбэл. Мөрөн хотын төв гудамж, Хужиртын даваа, Мянгадын гүүр, Хүрэнгийн хөндий, Тариа бригад гэхмэт.


2-р мөр: Газар нутгийн байдлыг ерөнхийд нь тайлбарлаж бичнэ.

Жишээлбэл: Уулархаг, талархаг, хэрчигдсэн гэхмэт.

3-р мөр: Паспортанд хөтлөгдөж буй замын километрийн хэмжээнүүдийг тоогоор /цифрээр/ бичиж тэмдэглэнэ. 0.0 замын эхлэл, 1.0км, 2.0км, 3.0 км гэхмэт.


4-р мөр: Тухайн замын техникийн зэрэг, ангилалыг ром тоогоор тэмдэглэнэ. Замын ангилалыг Авто зам төслөлтийн норм /БНБД 81-32-00/-д заасаны дагуу ангиллыг тогтоож тэмдэглэнэ. Жишээлбэл: I, II, III, IV, V, VI, VII....

5-р мөр: Замын тухайн хэсэг дэх дагуу налууг доорх маягаар тэмдэглэнэ.



Зураасны дээд талд налууг хувиар бичнэ. Зураасны доод, дээд талын төгсгөлд уг налуугийн уртыг бичнэ.

6-р мөр: Замын тухайн хэсэг дэх тойргийн радиусыг доорх маягаар тэмдэглэнэ.




Замын эргэлтийг дээрх маягаар тэмдэглэхдээ, радиусыг метрээр, тахирынхаа уртын хэмжээг эхлэл, төгсгөлд нь метрээр тус тус бичнэ.

7-р мөр: Хучилтын төрлийг харуулах товъёолсон тэмдэглэгээг ашиглан зохих мөрөө будаад уг мөрөн дотроо явах анги обочингийн хэмжээг доорх маягаар бичиж үзүүлнэ.

7	Хайрган	300	Асфальт	Асфальт бетон	Асфальт бетон
---	---------	-----	---------	---------------	---------------



8, 9-р мөр: Замын зурвасын орчинд замаас зүүн баруун гарт байгаа юмсын зураглалыг товъёог тэмдэглэгээг ашиглан зурж үзүүлнэ. /Гол горхи, Хот тосгон, овоо ухмал, ШТС, цахилгааны шугам гэхмэт/ зэргийг дэвсгэр зураг дээрх тэмдэглэгээгээр тэмдэглэнэ.



10-15-р мөр: Замын хучилтыг бүтээж байгаа үеүдийг, хэмжээнүүдтэй нь бичгээр бичиж хөтөлнө. Замын далангийн өргөн, Хучилтын өргөн, Хөвөөний өргөн, далан хучилт, суурь, шороон далангийн хөрсний материал зэргийг бичнэ.

16-р мөр: Хиймэл байгууламжийг доорх томъёолсон тэмдэглэлээр үзүүлнэ. Гүүр, хоолойг байрлуулан тэмдэглэхдээ 2-р мөрөнд байраа километрийн хэмжээтэй уялдуулна.

Гүүр, хоолойг тэмдэглэхдээ гүүр хоолойн төрөл, материал зэргээс хамааруулан доорх маягаар үзүүлнэ.



16	Г-7.0 450 ТБ 1 1995	Н-10 НК-30 75м 1995	Г-5.0 400 МГ 2 1976	Н-10 1.5x2 800 12.5м 1 ташуу	1.0 150 13.0м 2	2x2 470 13.0м 3	680 15.0м 4
----	---------------------------------	------------------------------	---------------------------------	---	--------------------------	--------------------------	-------------------

Гүүр хоолойг тухайн замын чиглэлийн эхнээс дугаарлаж, АЗХСТ-ын даргын тоот тушаалын 3, 4 дугаар хавсралтад заагдсан асуулгын дагуу Гүүрийн бүртгэл мэдээллийн карт, Хоолойн бүртгэл мэдээллийн картад тухайн гүүр хоолойны тухай нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээллийг бичиж, гүүр хоолойн ашиглалтын зургыг авч хавсаргана.

17, 18-р мөр: Өвлийн улиралд цас хунгарладаг, халтиргаа гулгаа үүсдэг замын хэсгүүдийг зам хариуцагчийн олон жилийн судалгааны үр дүнгээр тодорхойлж хэсгийн уртад тэмдэглэнэ.

Замын элстэй намагтай хэсгүүдийг мөн замын уртад хэмжиж тэмдэглэнэ.

19 - 23-р мөр: Авто замын техник ашиглалтын үзүүлэлтээр гаргасан утгуудыг харгалзах замын км бүрт гаргана.

24-р мөр: Тухайн чиглэлийн замын хамгийн сүүлд хийгдсэн хөдөлгөөний эрчмийн тооллогын дүнг тоогоор бичнэ.

25, 26-р мөр: Замын тэмдгүүдийг хялбар, ойлгомжтой тэмдэглэх бөгөөд тэмдэгийн ойролцоо “Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм”-д заасан тэмдгийн дугаарыг тэмдэглэнэ.

25	4.7 ○ 900		1.3 △ 800
26	250 □ 550 ○ 5.39 4.6	110 △ 1.20	300 ○ 4.4

27-р мөр: Авто замын үзэгдэх зайн хангалтыг төлөвлөлтийн үеийн тоон утгаар тэмдэглэнэ.

28 - 29-р мөр: Тухайн замын ашиглалтад орсон он болон анх ашиглалтад орох үеийн төсөвт өртгийг тэмдэглэнэ.

30-р мөр: Зам тээврийн ослын тухайн км-т гарсан тоог тэмдэглэнэ. Ослын шалтгааныг тусад нь мэдээлэлээр хавсаргана.

31-р мөр: Ашиглалтад орсноос хойш уг замд болон түүний хиймэл байгууламжид тухайн онд хийгдсэн засварын төрлийг бичнэ.

Тухайн жилд хийгдсэн /10 м-ээс дээшхи урттай гүүрүүдээс бусад/ бүх төрлийн засварын ажлын товч тэмдэглэл, төсөвт өртөг зэргийг замын засвар хийгдсэн тодорхой хэсгүүдтэй нь уялдуулан бичиж хавсаргана.

Засварын ажлын товч тодорхойлолтод доорх зүйлүүдийг бичнэ.

а. Засварын ажлуудын тодорхой нэр, Түүний тоо, хэмжээ, Өртөг, үнэ зэргийг замын км бүрт тодорхой бичнэ.

Жишээ нь: 0.0-1.0км-т 100м² Нүхний засвар, 700м² хөвөөний засвар, 10ш түмбэ сольсон, 5ш түмбэ будсан, гэх зэрэг элментийн мэдээнд орох мэдээллийг тодорхой бичиж хавсаргана.

32-р мөр: Авто зам, замын байгууламж барьсан байгууллагын нэр болон засвар арчлалтын хариуцагч байгууллагын нэрийг бичнэ.

33-р мөр: Авто замын км бүрийн газар зүйн байршилыг уртраг, өргөрөгөөр тодорхойлж градус, минут секундаар гаргаж тэмдэглэнэ.

33	N49 25.180 E105 56.542	N49 24.584 E105 56.523	N49 24.100 E105 56.042
-----------	---------------------------	---------------------------	---------------------------

Энэ тушаалын 5-р хавсралт буюу Авто замын газар зүйн байршлын жагсаалтад замын эхлэл, төгсгөл, зарим онцгой хэсгүүд, даваа, гүүр, хоолой, эргэлтийн эхлэл төгсгөл, замын хучилтын төрлийн эхлэл төгсгөл, зам дагуух суурин газар зэргийн координатыг тэмдэглэж тайлбарыг бичнэ.

Авто замын паспортой тухайн чиглэлийн замын км бүрийн ерөнхий байдлын зураг хавсаргасан байна.

Тухайн чиглэлийн авто зам, замын байгууламжийн ажлын зураг, төсөв, бусад тайлан мэдээллийг хавсаргаж болно.

----oOo----